



УВС АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Аймгийн ИТХ-ын захиалга, аймгийн Аудитын газрын 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийсэн нийцлийн аудитын тайлан.

**СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ЗЭЭЛИЙН АШИГЛАЛТ,
ЗАРЦУУЛАЛТ ҮР ДҮНГҮЙ БАЙНА.**

*Увс аймгийн Сум хөгжүүлэх сангаас 2016 онд олгосон
зээлийн ашиглалт, зарцуулалтын үр дүнд*

АГУУЛГА

<u>Тайлан бэлтгэсэн:</u> Дарга, тэргүүлэх аудитор Б.Авирмэд Аудитын менежер Ж.Энхжаргал Аудитор М.Бат-Амгалан Т.Намжил 2017 оны 5 дугаар сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7045-3721, 7045-3799 дугаарын утсаар харилцана уу. Хаяг: Увс аймгийн Аудитын газар Улаангом сум 3 баг Аймгийн Засаг даргын тамгын газрын байр	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй <i>Ерөнхий мэдээлэл</i> Бүлэг 1 Сум хөгжүүлэх сангийн зээлийн ашиглалт, зарцуулалт хангалтгүй байна. 1.1 Сум хөгжүүлэх сангийн зарим зээлийг хууль тогтоомж, журмын дагуу олгоогүй байна. 1.2 Сум хөгжүүлэх сангийн зээл авсан зарим зээлдэгч нар сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна. 1.3 Эргэн төлөгдөх зээл, хүүгийн орлогыг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд төвлөрүүлээгүй байна. Бүлэг 2 Сум хөгжүүлэх сангийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна. 2.1 Зээлийн гэрээний биелэлтэд тавих хяналт хангалтгүй байна. 2.2 Төсөл хэрэгжүүлснээр тодорхой түвшинд шинээр ажлын байр бий болгон ажиллажээ. Бүлэг 3 Өмнөх оны акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.. Дүгнэлт /бүлэг бүрт/ Зөвлөмж
--	---

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

1. Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг аймгийн ИТХ-ын захиалга, Аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

2. Аудитын зорилт

Сум хөгжүүлэх сангаас 2016 онд олгосон зээлийн ашиглалт, зарцуулалтын байдал хууль, тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллагад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Аудитыг дараах зорилтын хүрээнд хийж гүйцэтгэв. Үүнд:

- Сум хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалт түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэх;
- Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс олгосон зээл зориулалтын дагуу ашиглагдаж, зээлийн эргэн төлөлт гэрээний хугацаандаа төлөгдсөн эсэх

3. Хамарсан хүрээ

Увс аймгийн Сум хөгжүүлэх сангийн 2016 оны хөрөнгийн зарцуулалт, бүрдүүлэлт, хэрэгжилтийн байдлыг сумдын иргэдэд олгосон зээлийн холбогдох материалд тулгуурлан хийж гүйцэтгэлээ.

4. Арга зүй

Аудитын явцад холбогдох байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, төслийн хэрэгжилт, бодит байдалтай танилцах, зурагжуулах, судалгаа гаргуулах, зээлийн эргэн төлөлтийн байдлыг банкны хуулгатай тулган баталгаажуулах, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийсэн бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулах, мэдээ судалгаанд тулгуурлан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

Энэхүү нийцлийн аудитыг хийхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журам, нийцлийн аудитын түр журмыг баримталж ажиллав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлт, зөвлөмжид дэмжлэг болохуйц нотлох зүйлс, холбогдох бусад материалыг ажлын баримтад хавсаргав.

Нийцлийн аудитыг аймгийн Аудитын газрын аудитор М.Бат-Амгалан, Т.Намжил нар хийж гүйцэтгэлээ.

Хугацаа хойшилсон шалтгаан

Увс аймгийн 2016 оны төсвийн нэгдсэн гүйцэтгэлийн аудитыг Төсвийн тухай хуульд тусгагдсан цаглабарт хийж гүйцэтгэх болсон учир 7 хоногоор уг аудитыг хугацаа хойшилсон болно.

**Увс аймгийн Сум хөгжүүлэх сангаас 2016 онд олгосон зээлийн ашиглалт,
зарцуулалтын үр дүн**

Ерөнхий мэдээлэл

Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмаар тус сангийн хөрөнгийг удирдах, төсөл сонгон шалгаруулах, сангаас зээл олгох, эргэн төлөлт болон сангийн үйл ажиллагааг иргэдэд ил тод явуулахтай холбогдсон харилцааг зохицуулжээ.

Дээрх журмын 3.3.3-д “Сумын ИТХ нь сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөлийг тухайн сумын Засаг даргаар ахлуулан, Засаг даргын Тамгын газрын Төрийн сангийн мэргэжилтэн, Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо болон баг тус бүрээс нэг иргэний төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулах” гэж заасны дагуу сумууд орон тооны бус зөвлөл байгуулан 2016 онд гахайн аж ахуй, мах, махан бүтээгдэхүүн, талх, нарийн боов, модон эдлэл, газар тариалан эрхлэх, үхрийн ферм, цайны газар, хөнгөн болон хатуу оёдол, сүү, сүүн бүтээгдэхүүн, эсгий, эсгий бүтээгдэхүүн зэрэг үйлдвэрлэлийн зориулалтаар нийт 150 төсөл сонгон шалгаруулжээ.

Увс аймгийн хэмжээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2011-2017 онд сумдын Сум хөгжүүлэх санд 4229,9 сая төгрөгийн эх үүсвэрийг хуваариласан байна.

Сумуудад хуваарилсан Сум хөгжүүлэх сангийн санхүүжилт

/сая.төг/

№	Сумын нэр	2011 он	2013 он	2014 он	Нийт
1	Баруунтуруун	50.0	100.0	18.0	168.0
2	Бөхмөрөн	50.0	100.0	18.0	168.0
3	Давст	50.0	100.0	18.0	168.0
4	Завхан	50.0	100.0	18.0	168.0
5	Зүүнговь	50.0	100.0	35.1	185.1
6	Зүүнхангай	50.0	100.0	25.0	175.0
7	Малчин	50.0	100.0	24.0	174.0
8	Наранбулаг	60.0	120.0	36.8	216.8
9	Өлгий	50.0	100.0	18.0	168.0
10	Өмнөговь	60.0	120	24.0	204.0
11	Өндөрхангай	60.0	120.0	25.0	205.0
12	Сагил	50.0	100.0	18.0	168.0
13	Тариалан	60.0	120.0	24.0	204.0
14	Түргэн	50.0	100.0	18.0	168.0
15	Тэс	75.0	150.0	40.0	265.0
16	Ховд	50.0	100.0	28.0	178.0
17	Хяргас	50.0	100.0	28.0	178.0
18	Цагаанхайрхан	50.0	100.0	18.0	168.0
19	Улаангом	265.0	530.0	106.0	901.0
	Нийт	1230.0	2460.0	539.9	4,229.9

Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг тухайн сумын хүн амын тоонд суурилан хуваарилсан байна.

**Увс аймгийн Сум хөгжүүлэх сангаас 2016 онд олгосон зээлийн ашиглалт,
зарцуулалтын үр дүн**

Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаарх судалгаа

/сая.төг/

№	Сумын нэр	Нийт санхүүжилт	Алданги	Хүү торгууль	Нийт эх үүсвэр	Үйл ажиллагааны зардал	Дансанд бэлэн байгаа	Зээлдэгчдэд
1	Тариалан	204.0		31.0	235.0	8.4	28.5	198.1
2	Өндөрхангай	205.1		30.7	235.8	2.2	33.3	200.2
3	Улаангом	901.0		60.8	961.8	5.8	16.9	939.1
4	Цагаанхайрхан	168.0		32.3	200.3	1.9	15.8	182.6
5	Өлгий	168.0		14.3	182.3	1.2	0.5	180.6
6	Тэс	265.0	3.0	12.0	280.0	4.7	0.9	274.4
7	Наранбулаг	216.8	4.6	21.4	242.8	1.0	4.7	237.1
8	Завхан	168.0	2.3	22.2	192.5		2.7	189.8
9	Баруунтуруун	168.0		9.0	177.0	3.0	24.6	149.3
10	Түргэн	168.0	10.4	1.3	179.7	5.8	22.8	151.1
11	Зүүнхангай	175.0	1.3	12.4	188.7	0.8	29.8	158.1
12	Өмнөговь	204.0	4.8	18.5	227.3	2.8	9.3	215.2
13	Ховд	178.0	1.2	14.6	193.8	0.7	22.9	170.1
14	Сагил	168.0	3.2	12.5	183.7	0.6	14.9	197.3
15	Бөхмөрөн	168.0	7.8	16.4	192.2	3.4	70.1	118.7
16	зүүнговь	185.0	4.7	17.9	207.6	1.0	18.2	188.4
17	Хяргас	178.0	1.8	21.3	201.1	6.1	43.0	152.1
18	Малчин	174.0		15.3	189.3	2.6	10.0	176.8
19	Давст	168.0	1.5	11.5	181.0	2.4	29.1	149.5
	Дүн	4,229.90	46.60	375.40	4,651.90	54.40	398.00	4,228.50

Дээрх журмын 2.1-д “сангийн хөрөнгийн эх үүсвэр ... сангаас олгосон зээлийн хүүгийн орлого, хугацаандаа төлөөгүй зээлийн дүнд ногдуулсан алданги ... зэргээс бүрдэнэ” гэж заасны дагуу Увс аймгийн 19 суманд 4229.9 сая төгрөгийн санхүүжилт олгогдож, 2011-2017 оны 4 сарын байдлаар зээлийн хүүгээр 375.4 сая, алданги, торгуулиар 46.6 сая төгрөгийн орлого олж нийт 4651,9 сая төгрөгийн эх үүсвэртэй болсон байна. Сум хөгжүүлэх сангийн үлдэгдэл 398.0 сая, төсөл хэрэгжүүлэгч нарт олгосон зээлийн үлдэгдэл 4228.5 сая төгрөг байна.

Журмын 1.8-д “сангаас олгох зээлийн хүүгийн тухайн жилийн орлогын 30 хувийг зээлдэгчдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаанд зарцуулна” гэж заасны дагуу сумууд 54,4 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулжээ. Харин Давст сум 1.1 сая төгрөгөөр компьютер худалдан авч сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулжээ.

Үйл ажиллагааны зардалд тухайлбал Тариалан сум 8.4 сая, Хяргас 6.1 сая, Түргэн сум 5.8 сая, Улаангом сум 5.8 сая төгрөг зарцуулж сум хөгжүүлэх сангийн хөрөнгөд үрэлгэн хандаж байгаа нь харагдаж байна.

**Бүлэг 1 Сум хөгжүүлэх сангийн зээлийн ашиглалт, зарцуулалт
хангалтгүй байна.**

**1.1. Сум хөгжүүлэх сангийн зарим зээлийг хууль тогтоомж, журмын дагуу
олгоогүй байна.**

Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмыг шинэчлэн баталж, 2011 оны 134 дүгээр тогтоолоор баталсан журмыг хүчингүй болсон. Гэтэл 2016 онд зарим сум зээлдэгчдэд Засгийн газрын 134 дүгээр тогтоолоор батлагдсан журамыг баримталж жилийн 2 хувийн хүүтэй зээл олгох гэрээ байгуулсан байна. Тухайлбал 2016 онд Улаангом сумаас олгосон 23 зээлдэгчид 185.9 сая төгрөгийн зээлийг 2 хувиар тооцон гэрээ байгуулан олгожээ. Энэ нь Засгийн газрын 153 тоот тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих” журмын 1.6.1-д **“зээлийн хүүгийн хэмжээ нь жилд 3 хувь байна”** гэж заасныг зөрчиж байгаа тул дээрх журам батлагдсанаас хойш олгосон зээлүүдийн гэрээг зээлдэгч нартай дахин шинэчлэн байгуулахыг холбогдох сумдын Засаг дарга нарт албан шаардлага болголоо.

Дээрх журмын 4.2.3-д “сангаас зээл авч, төсөл хэрэгжүүлэх жижиг дунд үйлдвэр эрхлэгч иргэн, хуулийн этгээд зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах ... шаардлагыг хангасан байна” гэж заасныг зөрчин Улаангом сум иргэн Д.Дөлгөөнд Хадлан тариалангийн чиглэлээр 6.7 сая төгрөгийн зээлийг хуурамч баримт бүрдүүлэн олгож зориулалт бусаар зарцуулсан байна. Уг зээлийн эх үүсвэрийг ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэх өвс тэжээл худалдан авахад зарцуулсан гэх тайлбарыг өгч байна. Иймд зориулалт бусаар зарцуулсан 6.7 сая төгрөгийг Сум хөгжүүлэх санд төвлөрүүлэхийг албан шаардлага болголоо.

Засгийн газрын 2016 оны 153 тоот тогтоолоор батлагдсан Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын 4.2.1-д “сангаас зээл авч, төсөл хэрэгжүүлэх жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэн, хуулийн этгээд тухайн суманд бүртгэлтэй буюу **байнга оршин сууж үйл ажиллагаа явуулдаг байх**” гэж заасныг зөрчиж сангийн эх үүсвэрээс зээл авч төсөл хэрэгжүүлэгч нь тухайн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулахгүй байна. Тухайлбал:

- Улаангом сумын иргэн Н.Сувдаа хөнгөн оёдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар 15.0 сая төгрөгийн зээл авсан хэдий ч тухайн нутаг нутаг дэвсгэртээ зах зээл байхгүй гэдэг шалтгаанаар үйл ажиллагаа явуулахгүйгээр Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа гэсэн тайлбарыг өгч байлаа.
- Улаангом сумын иргэн Г.Нямсамбуу Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зориулалтаар 13.0 сая төгрөгийн зээл авсан ч шалгалтын явцад үйл ажиллагаатай танилцахад үйл ажиллагаа явуулаагүй, тоног төхөөрөмж аваад Баруунтуруун сум руу явуулсан гэх тайлбарыг өгч байна.
- Иргэн Б.Лхам-Эрдэнэ “Хүнсний бүтээгдэхүүн” үйлдвэрлэлийн зориулалтаар 10.0 сая төгрөгийн зээл авсан хэдий ч зээлдэгч Улаангом суманд амьдардаггүй тодруулбал сүүлийн жилүүдэд Солонгос улсад хүүхдээ эмчлүүлэн тэнд амьдарч байгаа гэсэн тайлбарыг зээлдэгчийн эгч нь утсаар өглөө.

Иймд сум хөгжүүлэх сангаас зээл аваад тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулахгүй байгаа төсөл арга хэмжээг буцаан татах арга хэмжээ авч ажиллахыг холбогдох сумын Засаг дарга нарт зөвлөмж болголоо.

Дээрх журмын 4.6-д “Сумын Засаг дарга төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулснаас хойш ажлын 7 хоногийн дотор зээлийн хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдийн дансанд шилжүүлнэ” гэж заасныг зөрчиж гэрээ

*Увс аймгийн Сум хөгжүүлэх сангаас 2016 онд олгосон зээлийн ашиглалт,
зарцуулалтын үр дүн*

байгуулсан дүнгээс дутуу, хувааж олгосон, 7 хоногт нь багтаж олгоогүй зөрчил байна. Тухайлбал:

- Улаангом сумын Засаг даргын 2015 оны 11 сарын 30-ны өдрийн захирамжаар төсөл хэрэгжүүлэгчдэд зээл олгохоор шийдвэрлэсэн боловч гэрээгээ 2016 оны 3-р, 4-р сард байгуулсан.
- Улаангом сумын иргэн Н.Соёлмаад 15.0 сая төгрөг олгохоор шийдвэр гарч 6.0 сая, Т.Цэвэгмэдэд 10.0 сая олгохоор шийдвэр гарч 6.0 сая, Т.Баттогтоход 6.0 сая төгрөг олгохоор шийдвэр гарч 4.0 сая төгрөгийн зээлийг тус тус олгосон байна.
- Улаангом сумын иргэн Г.Тэрбиштэй 2016 оны 07 сарын 14-нд 6.0 сая төгрөгийн зээлийн гэрээ байгуулж 2016 оны 8 сарын 6-нд 1.0 сая, 8 сарын 30-нд 1.0 сая, 9 сарын 19-нд 1.7 сая, 10 сарын 17-нд 1.6 сая, 10 сарын 24-нд 0.7 сая төгрөгийг тус тус цувруулан олгожээ.

Зээлийг хугацаандаа олгоогүйгээс зарим төсөл чанаргүй хэрэгжих, үйл ажиллагаа нь зогсох, шаардлагатай эх үүсвэрийг бүрэн олгодоггүйгээс төсөл хэрэгжүүлэх боломжгүй болох, зориулалт бусаар зарцуулсан гэсэн тайлбарыг төсөл хэрэгжүүлэгч нар өгч байлаа. Иймд зээлийн шийдвэр гаргасан тухай бүрт гэрээ байгуулж санхүүжилтийг олгож байхыг зөвлөлөө.

Дээрх журмын 6.2-д “Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй буюу энэ журамд заасныг зөрчиж төсөл сонгон шалгаруулсан, төслийн хэрэгжилтэд зохих журмын дагуу хяналт тавьж ажиллаагүй болох нь эрх бүхий этгээдийн хяналт шалгалтаар тогтоогдсон бол тухайн сумын Засаг дарга болон холбогдох бусад албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллахыг холбогдох албан тушаалтанд зөвлөмж болголоо.

1.2. Сум хөгжүүлэх сангийн зээл авсан зарим зээлдэгч нар сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

2016 онд зээл авсан 19 сумын 150 төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцахад үйл ажиллагаагаа эхлүүлээгүй, тоног төхөөрөмж аваад цааш үйл ажиллагаа явуулах эх үүсвэр хүрэлцээгүй, үйл ажиллагаа явуулах зориулалтын байргүй, үйл ажиллагаа явуулж байгаа эсэх нь тодорхойгүй, зээл аваад зориулалтын дагуу зарцуулаагүй, зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд нь төлөөгүй зэрэг зөрчлүүд илэрлээ.

Дээрх журмын 4.2.3-д “Сангаас зээл авч, төсөл хэрэгжүүлэх жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэн, хуулийн этгээд нь зээлийн хөрөнгийг **зориулалтын дагуу ашиглаж, хугацаанд төлөх төлбөрийн чадвартай**, барьцаа хөрөнгөтэй байх” гэсэн заалтыг хангаагүй байна. Тухайлбал:

Зүүнхангай сумын иргэн



Б.Балсанхүү гахайн аж ахуйн чиглэлээр 7.0 сая төгрөгийн зээл авсан хэдий ч төсөлд тусгасан гахай болон бусад тоног төхөөрөмжүүдийг аваагүй, гахайн байр гэж газар ухсанаас өөр ажил хийгээгүй байна.



Ц.Батболд хатуу оёдлын чиглэлээр 10.0 сая төгрөгийн зээлийг үйлдвэрлэлийн байр өргөтгөх, шинэ тоног төхөөрөмж худалдан авах зориулалтаар авсан ч үйлдвэрлэлийн байр гэж банзаар байшингийн рам босгосон, тоног төхөөрөмж аваагүй, үйл ажиллагаа нь эхлээгүй.

*Увс аймгийн Сум хөгжүүлэх сангаас 2016 онд олгосон зээлийн ашиглалт,
зарцуулалтын үр дүн*



Д.Бямбажав талх нарийн боовны чиглэлээр 5.0 сая төгрөг авч гэртээ дуков худалдан авсан, үйл ажиллагаа явуулах зориулалтын байр байхгүй, үйл ажиллагаагаа явуулж эхлээгүй.

Иргэн Б.Цэвэлмаа сүү, сүүн бүтээгдэхүүний чиглэлээр 6.0 сая, Б.Баяраа үхрийн фермийн чиглэлээр 10.0 сая төгрөгийн зээл тус тус авч үйл ажиллагаагаа эхлүүлээгүй байна.

➤ Цагаанхайрхан сумын иргэн



Д.Сайнбуян Сүү, цагаан идээ боловсруулах чиглэлээр 10.0 сая төгрөгийн зээл авч сүү боловсруулах машин гэж зэвэрсэн тоног төхөөрөмж хашаан дотор байгаагаас өөр зүйл байхгүй, үйл ажиллагаа явуулж цагаан идээ бэлтгэх тусгай байргүй, саалийн үхрээ аваагүй үйл ажиллагаагаа явуулж эхлээгүй,



Д.Лхагвасүрэн модон материал, төмөр хийцийн зориулалтаар 10.0 сая төгрөгийн зээл авсан ч явуулж буй үйл ажиллагаа тодорхойгүй, төслийн явцтай танилцахад ажлын байр гэж түлээний байраа харуулж байлаа.

➤ Улаангом сумын иргэн



О. Ганболд бичиг хэргийн чиглэлээр 12.0 сая төгрөгийн зээл авч тоног төхөөрөмж худалдан авсан ч ажиллуулж чадахгүйгээс үйл ажиллагаа явуулж эхлээгүй байна.



Н.Базаррагчаа модон материалын чиглэлээр 10.0 сая төгрөг авч өөр хүнд өгсөн тэр хүн нь хотод байгаа бид зээлийг хугацаанд нь төлөх болно гэсэн тайлбарыг зээлдэгчийн эхнэр өгч байлаа.



Д.Батболд Хатуу оёдолын чиглэлээр 5.0 сая төгрөгийн зээл авч 2.5 сая төгрөгөөр нь материал авч үлдэснээр нь ямаа худалдан авсан гэсэн тайлбарыг өгч байлаа.

Т.Баттогтох гэрийн оосор бүч хийх зориулалтаар 4.0 сая төгрөгийн зээл авч 2.0 сая төгрөгөөр нь материал авч, 2.0 сая төгрөгөөр нь зээл төлсөн гэсэн тайлбарыг өгч байна.

Т.Цэвэгмэд эсгий үйлдвэрлэлийн чиглэлээр 6.0 сая, Ц.Батням Эрдэс тэжээл боловсруулах чиглэлээр 4.0 сая төгрөгийн зээл авсан хэдий ч үйл ажиллагаа явуулаагүй байна.

**Увс аймгийн Сум хөгжүүлэх сангаас 2016 онд олгосон зээлийн ашиглалт,
зарцуулалтын үр дүн**

Журмын 3.5.3 “энэ журмын 3.5.2-т заасан төслийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээдтэй зохих журмын дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулж, биелэлтийг хангуулах, явц, үр дүнд байнгын хяналт тавьж ажиллах”, 5.2-д “Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгана” гэж заасны дагуу зориулалтын дагуу зарцуулаагүй болон үйл ажиллагаа эхлүүлээгүй төсөл хэрэгжүүлэгч нарын үйл ажиллагаанд хяналт тавьж зориулалт бусаар ашиглаж байгаа зээлийг буцаан төвлөрүүлэх, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллахыг холбогдох сумын Засаг дарга нарт зөвлөмж болголоо.

1.3. Эргэн төлөгдөх зээл, хүүгийн орлогыг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд төвлөрүүлээгүй байна.

Сум хөгжүүлэх сангаас зээл авч төсөл хэрэгжүүлэгч иргэн, жижиг дунд үйлдвэр эрхлэгчид дээрх журмын 4.7-д “Иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийг олгохдоо зээлдэгчдээ жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх туршлагатай, боломжтой эсэх, ажлын байртай эсэх, үйл ажиллагаа явуулах зах зээл байгаа эсэхийг сайн судлахгүйгээр танил тал, хамаатан садан бусад шалтгааныг харгалзан олгосноос зээлийг зориулалт бусаар ашигласан, зээлдэгч өөр газар шилжсэн, үйл ажиллагаа явуулахгүй байгаа зэрэг шалтгаанаас зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна.

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам болон төсөл хэрэгжүүлэгч иргэнтэй байгуулсан гэрээнд зээлийг зориулалт бусаар зарцуулсан, зээл, зээлийн хүүгээ хугацаанд нь төлөөгүй, гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээ, хариуцлагыг тодорхой заагаагүйгээс зээлийн хугацаа хэтрүүлсэн зээлдэгчид Шүүхийн шийдвэрээр эвлэрэх гэрээ байгуулснаас хойш сангийн хөрөнгийг хүүгүйгээр олон сар, жилээр үргэлжүүлэн ашиглах боломж бүрдүүлж байна.

Увс аймгийн 19 сумын нийт 366 зээлдэгчтэй холбоотой гэрээнд заасан зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн, төлөгдөөгүй зээлийн үлдэгдэл 1583.8 сая, алданги 85.6 сая, нийт 1669.4 сая төгрөг байна.

Сумдын хугацаа хэтэрсэн зээлдэгчийн судалгаа

№	Сумдын нэрс	Зээлдэгчийн тоо	Хугацаа хэтэрсэн		Нийт дүн
			Төлөгдөөгүй үлдэгдэл	Алданги торгууль	
1	Баруунтуруун	12	93,3		93,3
2	Бөхмөрөн	10	32,2	4,3	36,5
3	Давст	10	67,7	1,6	69,3
4	Завхан	6	66,8	8,9	75,7
5	Зүүнговь	13	87,8	3,3	91,1
6	Зүүнхангай	10	46,6	4,0	50,6
7	Малчин	10	31,7	1,4	33,1
8	Наранбулаг	20	122,2	6,0	128,2
9	Өлгий	23	73,8	1,6	75,4
10	Өмнөговь	13	61,6	3,4	65,0
11	Өндөрхангай	17	15,2	4,5	19,7
12	Сагил	16	104,3	1,4	105,7
13	Тариалан	7	15,2	4,5	19,8
14	Түргэн	20	77,3	0,5	77,8
15	Тэс	35	166,6	20,0	186,6
16	Ховд	9	33,7	6,1	39,8
17	Хяргас	34	106,4		106,4
18	Цагаанхайрхан	15	33,4	0,9	34,3
19	Улаангом	86	281,4	16,2	297,6
	Дүн	366	1583,7	85614,7	1669,4

/сая.төг/

Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс авсан 1669.4 сая төгрөгийн зээлийг гэрээнд заасан хугацаандаа төлөөгүйгээс дараагийн төслийг санхүүжүүлэх боломжийг бүрдүүлэхгүй байна.

Түүнчлэн Цагаанхайрхан сумаас бусад 18 сум зээлийн хугацаа хэтэрсэн 212 зээлдэгчийг аймгийн Аудитын газрын өмнөх оны нийцлийн аудитын актыг үндэслэн Шүүхэд шилжүүлснээс 119 зээлдэгчийн зээлийн төлбөрийг тодорхой хугацаа зааж төлүүлэхээр эвлэрсэн, 39 зээлдэгчээр төлүүлэхээр Шүүхийн шийдвэр гарсан, 14 зээлдэгч Шүүхийн шатанд хянагдаж байна. Зарим эвлэрлийн гэрээ байгуулсан зээлдэгчид заасан хугацаанд зээлээ төлөөгүйн улмаас дахин Шүүхэд нэхэмжлэл гаргах асуудал гарсаар байна. /Хавсралт №1/

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба нь 2017 оны 4 сарын байдлаар Шүүхээс шилжиж ирсэн нийт 30 зээлдэгчийн 228.5 сая төгрөгийн зээлээс 35.5 сая төгрөгийн зээлийг барагдуулж, 193.0 сая төгрөгийн зээлийг хөрөнгө битүүмжлэх, борлуулах, зээлийг төлөх тодорхой хугацаа өгөх зэргээр үйл ажиллагаа явуулан барагдуулах шатанд байгаа судалгаа ирүүлсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд шилжсэн зарим зээл төлөгдөөгүй байхад төлсөн гэсэн судалгаа ирүүлсэн байна.

Тухайлбал: Хяргас сумын иргэн С.Сүхбаатар 2013 онд 20.0 сая төгрөгийн зээл авч гэрээний хугацаанд зээл төлөөгүйгээс Шүүхэд 11.3 сая төгрөгийн зээлийг шилжүүлсэн байна. Шүүхийн шийдвэр гарч ШШГА-нд зээлийг төлүүлэхээр шилжүүлснийг Хяргас сумын Засаг дарга байсан Т.Сүхтулга зээлдэгч С.Сүхбаатарын сум хөгжүүлэх сангаас авсан зээлийн барьцаа хөрөнгө болох мал, газар зэрэг хөрөнгийг зээлийн төлбөрт тооцон авч сум хөгжүүлэх сан хохиролгүй болсон, зээлдэгч Г.Гантогтох зээлийн үлдэгдэлтэй байхад мөн бүрэн төлж барагдуулсан тул уг зээлүүдийг хааж өгөхийг хүссэн албан тоотыг ШШГА-нд хүргүүлжээ. ШШГА уг албан тоотыг үндэслэн зээлүүдийг төлсөн гэсэн судалгааг ирүүлсэн байна.

Үүнээс үзэхэд зээлийн үйл ажиллагаанд хяналт тавих албан тушаалтан өөрийн эрх мэдлийг хэтрүүлэн ашиглаж хуурамч албан тоот үйлдсэн, ШШГА-ны шийдвэр гүйцэтгэгч нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 16.1.2-т “шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр төлөгч төлбөрөө бүрэн төлсөн нөхцөлд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болсонд тооцож, шийдвэр гарган, гүйцэтгэх баримт бичгийг хаана” гэж заасныг зөрчин зээлийн төлбөрийг барагдуулсан эсэхийг магадлаагүй хэрнээ Шүүхийн шийдвэрийг хаасан байна.

Иймд ШШГА-ны уг асуудлыг хариуцсан шийдвэр гүйцэтгэгчид Төрийн аудитын тухай хуулийн 28.1 дэх заалтыг үндэслэн нийцлийн аудитаар материаллаг шинжтэй алдаа гаргасан тул хариуцлагын арга хэмжээ авч, хуурамч албан тоотыг үндэслэн хаасан зээлүүдийг зээлдэгч нараар төлүүлж биелэлтийг ирүүлэхийг албан шаардлага болголоо.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шатанд үйл ажиллагаа явуулахад зарим зээлдэгч нас барсан, шилжиж явсан, хаяг тодорхойгүй, хураах хөрөнгөгүй байгаа гэсэн тайлбар ирүүлж байгаагаас үзэхэд Сум хөгжүүлэх сангийн зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам болон зээлдэгчтэй байгуулсан гэрээнд хамтран зээлдэгчийн мэдээллийг тодорхой тусгаж хариуцлагдажүүлж өгөх шаардлагатай байна. Энэ асуудлаар холбогдох дээд шатны байгууллагад хандаж журамд өөрчлөлт оруулах арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтанд зөвлөж байна.

Тус журмын 6.3-д “энэ журмыг зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэх бөгөөд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу гэм буруутай этгээд хариуцан барагдуулна” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаж хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүг барагдуулах тодорхой ажил зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт зөвлөмж болголоо.

Бүлэг 2 Сум хөгжүүлэх сангийн зээлийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.

2.1. Зээлийн гэрээний биелэлтэд тавих хяналт хангалтгүй байна.

Сумдын Засаг дарга нар сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн гэрээг тус журмын дагуу төсөл хэрэгжүүлэгч иргэдтэй байгуулсан байна.

Дээрх журмын 3.3.2-д “Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг тухайн сумын ИТХ-ын тэргүүлэгчээр ахлуулан, ЗДТГ-ын төрийн сангийн мэргэжилтэн, Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо болон баг тус бүрээс нэг иргэний төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулах” гэж заасан байхад сумууд хяналтын зөвлөлөө шинэчлэн байгуулаагүй, зээлдэгчийн үйл ажиллагаанд хяналт хийгээгүй байна. Тухайлбал: Улаангом сум 2015 оны 09 сарын 18-нд байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн шинэчлэгдээгүй, хяналт хийгдээгүй байна.

Төсөл хэрэгжүүлэгч иргэнтэй байгуулсан зээлийн гэрээний 3.3-т “Авсан зээл, түүний хүүгийн төлбөрийг энэхүү гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд зээлдэгчийн харилцах данснаас үл маргах журмаар төлүүлэх, зохих журмын дагуу зээлийг төлүүлэх шаардлагатай бусад арга хэмжээ авна” гэж заажээ.

ИТХ-ын тогтоолоор батлагдсан сангийн үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хэсэг нь журмаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхгүй байгаагаас жил бүр тухайн зөрчил дутагдал давтан гарсаар байна.

Иймд сумдын сум хөгжүүлэх сангийн зээл сонгон шалгаруулах болон зээлийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавих ажлын хэсгийг шинэчлэн байгуулж журмын дагуу хяналт тавьж байхыг зөвлөмж болголоо.

2.2. Төсөл хэрэгжүүлснээр тодорхой түвшинд шинээр ажлын байр бий болгон ажиллажээ.

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 4.3.6-д “төсөл хэрэгжүүлэгч иргэн хуулийн этгээдийн боловсруулсан төсөл нь ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн байх” гэсэн шаардлагын дагуу төсөл хэрэгжүүлэгч нар тодорхой түвшинд шинээр ажлын байр болгож ажиллажээ.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн байдал

	Сумдын нэрс	Нийт зээл авсан иргэн, ААН-ийн тоо	Шинээр бий болсон ажлын байр	НДШ төлсөн даатгуулагчийн тоо
1	Баруунтуруун	8	8	3
2	Бөхмөрөн	-	-	-
3	Давст	2	4	3
4	Завхан	7	11	8
5	Зүүнговь	10	12	11
6	Зүүнхангай	15	20	9
7	Малчин	13	13	
8	Наранбулаг	-	-	-

**Увс аймгийн Сум хөгжүүлэх сангаас 2016 онд олгосон зээлийн ашиглалт,
зарцуулалтын үр дүн**

9	Өлгий	8	18	2
10	Өмнөговь	5	11	4
11	Өндөрхангай	5	9	4
12	Сагил	2	3	2
13	Тариалан	13	17	15
14	Түргэн	4	7	2
15	Тэс	14	14	10
16	Ховд	4	8	4
17	Хяргас	9	13	11
18	Цагаанхайрхан	9	12	2
19	Улаангом	23	24	6
	Дүн	150	184	96

2016 онд аймгийн хэмжээнд 150 иргэн, жижиг дунд үйлдвэр эрхлэгч төсөл хэрэгжүүлж, 184 шинээр ажлын байр бий болгохоор төлөвлөсөн ч 96 иргэн буюу 52.2 хувьд нь НДШ төлсөн байна. Үүнээс харахад шинээр бий болсон ажлын байр төлөвлөгдсөн хэмжээнд хүрээгүй ч тодорхой түвшинд хэрэгжүүлэн ажилласан байна.

**2.3. Өмнөх оны акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж
ажиллаагүй байна.**

2016 онд хийсэн Сум хөгжүүлэх сангийн зарцуулалтын үр дүнд хийсэн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар 839.6 сая төгрөгийн 21 акт тогтоосноос 215.7 сая төгрөгийн акт барагдаж, 511.2 сая төгрөгийн акт хууль хяналтын байгууллагад шилжсэн 112.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Түүнчлэн 121.0 сая төгрөгийн зөрчил арилгуулах 5 албан шаардлагаас 105.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулж, 5 зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байна. Дээрх хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудлаас 235.9 сая төгрөгийн зээлийн төлбөрийг төлөх Шүүхийн шийдвэр гарсан байна.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.
Үүнд:

1. Гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлж ажиллаагүйгээс зээлийг зориулалт бусаар зарцуулсан, зээлийг хугацаанд нь төлөөгүй, үйл ажиллагаагаа эхлүүлээгүй, төсөл хэрэгжүүлэгч өөр газар амьдарч байгаа зэрэг зөрчлүүд байна.
2. Төсөл хэрэгжүүлэгч иргэнтэй байгуулсан гэрээнд зээлийг зориулалт бусаар зарцуулсан, хугацаандаа зээлийг төлөөгүй, гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээ, хариуцлагыг тодорхой заалтаар тусгаж оруулаагүй байна.
3. Төсөл хэрэгжүүлэгч иргэнтэй байгуулсан гэрээний талуудад зөвхөн зээлдүүлэгч, зээлдэгч нар байгаа нь аль нэг хуулийн этгээд өөр газар шилжих, нас барах зэрэг аливаа эрсдэлийг тооцохгүйгээр гэрээ байгуулсан байна.
4. ИТХ-ын тогтоолоор байгуулагдсан орон тооны бус хяналтын зөвлөл зээлийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж дүнг ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, сумын нийт иргэдэд мэдээлээгүй байна.

Холбогдох байгууллагын санал


**УВС АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД**
213400, Улаангом сум, Увс аймаг
Регистр: 9062858,
Утас/факс: 70452113

2017.05.17 № 136
танай _____-ны № _____-т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ХАРЬЯА УВС АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Аймгийн ИТХ-ын захиалга, Аймгийн Аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу "Аймгийн сум хөгжүүлэх хөгжлийн сангаас 2016 онд олгосон зээлийн ашиглалт, зарцуулалтын үр дүн"-д хийсэн нийцлийн аудитын тайлантай танилцлаа. Уг нийцлийн аудитыг бүх сумдыг хамруулан, зээлийн олголт, зарцуулалт, эргэн төлөлтөнд хийсэн байна.

Уг санд хийсэн нийцлийн аудитын дүгнэлт, зөвлөмжтэй санал нэг байна. Тайлантай холбоотой гарсан дүгнэлт, зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудаар хэрэгжүүлж ажиллах болно.

ДАРГА  Э.НАСАНБАТ



Увс аймгийн Сум хөгжүүлэх сангаас 2016 онд олгосон зээлийн ашиглалт,
зарцуулалтын үр дүн



УВС АЙМАГ
УЛААНГОМ СУМЫН ЗАСАГ ДАРГА

213400, Улаангом, Увс аймаг
Утас/факс: 7045-3030

2017.05.17 № 418
танай -ны № -т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Санал хүргүүлэх тухай

Сум хөгжүүлэх сангаас 2016 онд олгосон зээлийн ашиглалт, зарцуулалтын үр дүнд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Сумдын Засаг даргын нөөц хөрөнгөд жил бүр 5 сая төгрөг тусгагддаг бөгөөд 2016 оны 11 дүгээр сард тухайн хөрөнгө зарцуулагдаж дууссан бөгөөд өрийн үлдэгдэлтэй байсан.

2016-2017 оны өвөлжилтийн байдал хүндэрч, гамшгийн байдалд хүрэхэд Улаангом суманд өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэлт огт байгаагүй, хөрөнгийн эх үүсвэр ч байхгүй байлаа.

Энэхүү байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс 6.7 сая төгрөг гарган сумын өвс, тэжээлийн фонд бүрдүүлж байгалийн цаг үеийн гамшгийг малын хорогдол багатай, амжилттай даван туулсан.

Сумын ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 2/10 тоот тогтоолоор Орон нутгийн хөгжлийн сангаас сумын өвс, тэжээлийн фондод 15 сая төгрөг тусгагдсан тул дээрхи 6.7 сая төгрөгийг буцаан төвлөрүүлнэ.

Цаашид сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг зориулалтын дагуу, холбогдох журмыг баримтлан ажиллана.

ЗАСАГ ДАРГА



Ц.ПҮРЭВЖАВ

*Увс аймгийн Сум хөгжүүлэх сангаас 2016 онд олгосон зээлийн ашиглалт,
зарцуулалтын үр дүн*

Холбогдох байгууллагын саналд өгөх хариу

Увс аймгийн Сум хөгжүүлэх сангаас 2016 онд олгосон зээлийн ашиглалт, зарцуулалтын үр дүнд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж аймгийн ИТХ-ын 2017 оны 05 сарын 17-ны өдрийн 136 тоот, Улаангом сумын Засаг даргын 2017 оны 05 сарын 17-ны өдрийн 418 тоот албан тоотуудыг үндэслэн тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Зөвлөмж: Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Сумдын Засаг дарга нарт:

1. Төсөл хэрэгжүүлэгч нь зээлийг зориулалт бусаар зарцуулсан, зээлийг хугацаанд нь төлөөгүй, үйл ажиллагаагаа эхлүүлээгүй, төсөл хэрэгжүүлэгч өөр газар шилжсэн, үйл ажиллагаа явуулж байгаа нь тодорхойгүй зэрэг зөрчлийг арилгаж тодорхой ажил зохион байгуулж ажиллах.
2. Төсөл хэрэгжүүлэгч иргэнтэй байгуулсан гэрээнд зээлийг зориулалт бусаар зарцуулсан, хугацаандаа зээлийг төлөөгүй, гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээ, хариуцагын талаар тодорхой заалтуудыг тусгах.
3. Төсөл хэрэгжүүлэгч иргэнтэй зээлийн гэрээ байгуулахдаа төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой үүссэн хариуцлагыг хамтран хүлээхээр гэрээнд тодорхой тусгах.
4. Зээлийн хэрэгжилтэнд хяналт тавих ажлын хэсгийг шинээр байгуулж, хяналт шалгалт хийлгэж дүнг ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, сумын нийт иргэдэд мэдээллэх.

ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТОР

М.БАТ-АМГАЛАН

Т.НАМЖИЛ